



ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН БҮРТГЭЛ, ЭЛСЭЛТЭД ҮЗҮҮЛЭХ БАРИМТ БИЧГҮҮД

Эцэг, эхүүд өөрсдийн хүүхдийг дагуулж ирж, дараах баримт бичгүүдийг үзүүлнэ*:

1P- 8P: ЖЕНЕВТ ОРШИН СУУДАГ СУРАГЧИД

➤ Хүүхдийн нэрийг зааж өгсөн нэг албан ёсны баримт бичиг:

(иргэний үнэмлэх, гадаад паспорт, гэр бүлийн дэвтэр/гэрчилгээ, төрсний гэрчилгээ, Женевт амьдрах зөвшөөрлийн бичиг эсвэл Женев кантоны хууль ёсны үнэмлэх)

➤ бүртгүүлэх өдөр хүүхдийг дагалдан яваа эцэг эхийн албан ёсны бичиг баримт:

(иргэний үнэмлэх, гадаад паспорт, Женевт амьдрах зөвшөөрлийн бичиг эсвэл Женев кантоны хууль ёсны үнэмлэх)

➤ Эрүүл мэндийн даатгалтай гэсэн нотолгоо (LAMal):

(танай эрүүл мэндийн даатгалаас өгсөн гэрчилгээ эсвэл хүчин төгөлдөр даатгалын үнэмлэх)

Хууль ёсны үнэмлэхтэй хүүхдүүд эцэг эхийн ажлаас олгосон эрүүл мэндийн даатгалд бүртгэлтэй гэсэн гэрчилгээг үзүүлэх боломжтой.

➤ Түрээсийн гэрээ болон сүүлийн 3 сарын дотор олгосон “GIS” нэхэмжлэх;

➤ Кантоны Хүн ам, Шилжин суурьшлын байгууллагаас (“ОСРМ”) (эсвэл сонгогчийн сүүлчийн үнэмлэх) хүүхдэд болон эцэг, эхийн аль нэгт эсвэл хүүхэдтэй хамт амьдарч байгаа хууль ёсны төлөөлөгчид олгосон сүүлийн гурван сарын доторх огноотой оршин суугчийн гэрчилгээ.х (<https://www.ge.ch/obtenir-attestation-ocpm>);

Хууль ёсны үнэмлэхтэй хүүхдүүд эцэг, эхийн ажил олгогчоос гэр бүлд олгосон Женев кантоны оршин суугчийн үнэмлэхийг үзүүлэх боломжтой. Энэ баримт бичиг нь түрээсийн гэрээ эсвэл “GIS” нэхэмжлэхийг орлоно.

*нэмэлт баримт бичиг шаардаж магадгүй.